



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2014 оны 12 сарын 31 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Иргэний нисэхийн ерөнхий газрын
зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 заалт, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 заалт, Иргэний нисэхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 заалтыг тус тус үндэслэн “Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2014 оны 387 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Иргэний нисэхийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийг хавсралт ёсоор баталсугай.
2. Батлагдсан зохион байгуулалтын бүтцийн дагуу үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг боловсруулан 2015 оны 1 дүгээр сарын 25-ны дотор батлуулахыг Иргэний нисэхийн ерөнхий газар/Т.Лхагвасүрэн/-т даалгасугай.
3. Өөрийн шууд харъяа алба, байгууллагын зохион байгуулалтын бүтцийг Иргэний нисэхийн асуудал хариуцсан Төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авч батлахыг Иргэний нисэхийн ерөнхий газар/Т.Лхагвасүрэн/-т үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Иргэний нисэхийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийг батлах тухай” Зам, тээврийн сайдын 2013 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 68 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Н.ТӨМӨРХҮҮ

Зам, тээврийн сайдын 2014 оны 18 дугаар сарын 31-ны өдрийн 13 дугаар тушаалын хавсралт

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ - ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ**

